



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/1171

Зуунмод

Салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.4, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 402 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журмын 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дэд дарга :

(Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

(Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтэн)

(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)

(Авто тээврийн төвийн дарга)

(Барилга захиалагч орон сууцны корпорацын дарга)

(Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга)

(Эрүүл мэндийн газрын дарга)

(Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

(Нийгмийн даатгалын газрын дарга)

(Цахим хөгжлийн хэлтсийн дарга)

(Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Төв ОНХХөтөлбөрийн менежер).
(зөвшилцсөнөөр)

(Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн)

(зөвшилцсөнөөр)

(Хараагүйчүүдийн холбооны тэргүүн)

(Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны тэргүүн)

(зөвшилцсөнөөр)

4124010418

Нарийн бичгийн дарга:

(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/57 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР